


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ  
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,  
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН  
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



# МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



## Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 6 сард **13,264.6** сая ам.доллар болж 2023 оны мөн үеэс 1,426.6 сая ам.доллар буюу

12.1 хувиар өсчээ. Экспортын дүн импортын дүнгээс 2,507.8 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 6 сар				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	7,334.2	9,257.1	11,838.1	13,264.6	1,426.6	12.1
-Экспорт	4,072.7	5,309.1	7,564.4	7,886.2	321.8	4.3
-Импорт	3,261.5	3,948.0	4,273.6	5,378.4	1,104.8	25.9
Тэнцэл	811.2	1,361.1	3,290.8	2,507.8	-783.0	-23.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **2,507.8** сая ам.долларын ашигтай гарсан байна. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 783.0 сая ам.доллараар буурахад мпортын өсөлт экспортын өсөлтийг давсан нь нөлөөлсөн байна.

мөн үетэй харьцуулахад 321.8 сая ам.доллар буюу 4.3 хувиар өссөн байна.

**Импорт:** 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр импорт **5,378.4** сая ам.долларт хүрч, 2023 оны мөн үетэй харьцуулахад 1,104.8 сая ам.доллар буюу 25.9 хувиар өссөн байна.

**Экспорт:** Экспортын худалдаа 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **7,886.2** сая ам.доллар болж, 2023 оны

### Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын 89.0 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 11.0 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

сая ам.доллар буюу 6.4 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 870.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 99.2 сая ам.доллар буюу 10.2 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 7,016.2 сая ам.доллар болж, өмнөх оноос 421.0

**Хүснэгт 2.** Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 6 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	3,389.4	4,437.1	6,595.3	7,016.2	421.0	6.4	89.0
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	721.9	871.2	969.2	870.0	-99.2	-10.2	11.0
Нийт экспорт	4,111.3	5,308.3	7,564.4	7,886.2	321.8	4.3	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 59.3 хувийг нүүрс, 18.4 хувийг зэсийн баяжмал, 4.5 хувийг боловсруулаагүй алт, 3.7 хувийг төмрийн

хүдэр, 2.1 хувийг боловсруулаагүй нефть тус тус эзэлсэн байна

**Хүснэгт 3.** Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 6 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	764.3	785.2	20.8	2.7
Нүүрс	сая.тн	28.4	39.4	11.1	39.1
Төмрийн хүдэр	сая.тн	2.7	3.6	0.9	34.1
Цайрын баяжмал	мян.тн	100.1	62.1	-38.1	-38.0
Алт	тн	5.4	5.0	-0.3	-6.5
Боловсруулаагүй нефть	сая.баррель	2.4	2.1	-0.3	-12.3
Катодын зэс	мян.тн	6.4	6.1	-0.3	-4.7
Жоншны баяжмал	мян.тн	436.4	583.8	147.4	33.8
Адууны мах	мян.тн	14.6	5.0	-9.6	-65.9
Өлөн гэдэс	тн	272.6	323.3	50.7	18.6

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	10.0	21.2	11.2	111.5
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	254.6	185.8	-68.8	-27.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	34.3	0.4	-33.9	-98.8
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	39.7	30.8	-8.9	-22.5
Ямааны самнасан ноолуур	тн	337.3	278.5	-58.8	-17.4
Ямааны угаасан ноолуур	мян.тн	2.3	2.7	0.4	15.6
Самнаагүй хонины ноос	мян.тн	5.8	1.9	-3.8	-66.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

#### Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	эхний 6 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	1,329.8	1,454.4	124.6	9.4	18.4
Нүүрс	4,331.2	4,675.3	344.2	7.9	59.3
Төмрийн хүдэр	229.2	292.5	63.3	27.6	3.7
Цайрын баяжмал	164.2	85.4	-78.8	-48.0	1.1
Алт	337.6	356.0	18.4	5.5	4.5
Боловсруулаагүй нефть	175.2	165.8	-9.4	-5.3	2.1
Катодын зэс	54.1	52.5	-1.6	-2.9	0.7
Жоншны баяжмал	117.7	130.3	12.6	10.7	1.7
Адууны мах	53.6	17.6	-36.0	-67.2	0.2
Өлөн гэдэс	4.3	6.3	2.1	48.6	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.6	0.4	-0.2	-35.4	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.6	0.5	-0.2	-29.1	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.5	0.0	-0.5	-99.2	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	1.0	0.8	-0.2	-19.4	0.0
Ямааны самнасан ноолуур	33.8	28.4	-5.4	-16.0	0.4
Ямааны угаасан ноолуур	114.2	146.3	32.1	28.1	1.9
Самнаагүй хонины ноос	6.2	2.1	-4.1	-65.6	0.0
<b>Нийт экспортод эзлэх хувь</b>					<b>94.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

/ам.доллар/

#### Хүснэгт 5. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 6 сар		Өөрчлөлт	
		2023	2024	Дүн	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	152.8	118.5	-34.2	-22.4
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,739.8	1,852.4	112.5	6.5
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	85.5	81.3	-4.2	-4.9
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,639.8	1,376.6	-263.1	-16.0
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	269.7	223.2	-46.5	-17.3
Алт	кг/ам.дол	62,539.3	70,519.2	7,979.9	12.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс **421.0** сая ам.доллар буюу 6.0 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**Нүүрс:** 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 4,675.3 сая ам.долларын 39.4 сая.тн чулуун нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 344.2 (7.9%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 11.1 (39.1%) сая.тн-оор тус тус өссөн байна. Чулуун нүүрсний 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Зэсийн баяжмал:** 2024 оны эхний 6 сарын байдлаар 1,454.4 сая ам.долларын 785.2 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 124.6 (9.4%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 20.8 (2.7%) мян.тн-оор тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Алт:** 2024 оны эхний 6 сарын байдлаар 356.0 сая ам.долларын 5.0 тонн алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 18.4 (5.5%) сая ам.доллараар өссөн ч, биет хэмжээгээр 0.4 (6.5%) тонноор буурсан байна. Алтыг 95.4 хувийг Швейцар, 4.0 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна.

**Төмрийн хүдэр:** 2024 оны эхний 6 сарын байдлаар 292.5 сая ам.долларын 3.6 сая.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 63.3 (27.6%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 0.9 (34.1%) сая.тн-оор тус тус өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Газрын тосны экспорт:** 2024 оны эхний 6 сарын байдлаар 165.8 сая ам.долларын 2.1 сая.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 0.3 (12.3%) сая.бар-иар, үнийн дүнгээр 9.4 (5.3%) сая ам.доллараар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

## Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **22.3** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **77.7** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,201.5** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 192.6 сая ам.доллараар буюу 19.1 хувиар өссөн байна.

Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **4,177.0** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 912.2 сая ам.доллар буюу 27.9 хувиар өссөн байна.



**Хүснэгт 6. Эрдсийн бүтээгдэхүүний импорт**

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 6 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	386.5	484.0	1,008.9	1,201.5	192.6	19.1	22.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	1,304.2	1,455.6	3,264.7	4,177.0	912.2	27.9	77.7
<b>Нийт импорт</b>	<b>1,690.7</b>	<b>1,939.6</b>	<b>4,273.6</b>	<b>5,378.4</b>	<b>1,104.8</b>	<b>25.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 22.3 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 21.0 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 21.0 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.6 хувь, хүнсний бүтээгдэхүүн 7.1 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр**

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Бүтэц (хувиар)
		2023	2024	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	71.5	66.5	-5.1	-7.1	1.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	70.2	104.1	33.9	48.3	1.9
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	16.8	18.6	1.8	11.0	0.3
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	308.9	382.4	73.5	23.8	7.1
5	Эрдэс бүтээгдэхүүн	1,008.9	1,201.5	192.6	19.1	22.3
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	236.3	279.0	42.7	18.1	5.2
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	176.8	178.8	2.0	1.1	3.3
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	4.9	4.5	-0.3	-6.9	0.1
9	Мод, модон эдлэл	34.7	49.9	15.1	43.6	0.9
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	39.1	40.1	1.0	2.6	0.7
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	62.6	63.8	1.3	2.0	1.2
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	16.8	18.3	1.5	8.9	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	106.0	113.8	7.8	7.3	2.1
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	1.8	2.2	0.4	21.0	0.0
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	378.1	463.2	85.1	22.5	8.6
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	775.6	1,130.7	355.0	45.8	21.0
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	827.0	1,127.0	299.9	36.3	21.0
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	64.1	63.9	-0.2	-0.3	1.2
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	72.2	68.9	-3.3	-4.6	1.3
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.1	0.0	-0.1	-79.0	0.0
21	Бусад	1.2	1.2	0.1	6.9	0.0
	<b>ДҮН</b>	<b>4,273.6</b>	<b>5,378.4</b>	<b>1,104.8</b>	<b>25.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

## Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2024 оны эхний 6 сард нийт **3,297.3** тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **3,072.7** тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэйгээр буюу **93.2** хувьтай байна.

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 581.5 тэрбум төгрөгөөр буюу 23.3 хувиар өссөн байна.

### Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023.06		2024.06		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	гүйц.	төлөв.	гүйц.	зөрүү	хувь	зөрүү	хувь	
<b>Нийт орлого</b>	<b>2,491.1</b>	<b>3,297.3</b>	<b>3,072.8</b>	<b>581.7</b>	<b>23.4</b>	<b>-224.5</b>	<b>-6.8</b>	
Гаалийн албан татвар	685.6	948.2	814.9	129.3	18.9	-133.3	-14.1	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,486.2	1989.9	1802.6	316.4	21.3	-187.3	-9.4	
Архи, дарсны онцгой албан татвар	15.1	24.5	27.2	12.1	80.1	2.7	11.0	
Тамхины онцгой албан татвар	69.4	73.5	68.2	-1.2	-1.7	-5.3	-7.2	
Шар айрагны онцгой албан татвар	2.9	4.9	4.8	1.9	65.5	-0.1	-2.0	
Суудлын автомашины онцгой албан татвар	140.9	161.7	263	122.1	86.7	101.3	62.6	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	10.4	9.8	2.3	-8.1	-77.9	-7.5	-76.5	
Автобензин, дизель түлшний албан татвар	10.2	13.7	12.5	2.3	22.5	-1.2	-8.8	
Экспортын татвар	0.0	0.02	0.022	0.0	-37.1	0.0	10.0	
<b>Татварын дүн</b>	<b>2,420.7</b>	<b>3,226.2</b>	<b>2,995.5</b>	<b>574.8</b>	<b>23.7</b>	<b>-230.7</b>	<b>-7.2</b>	
Хураамж	53.1	63.7	71.4	18.3	34.5	7.7	12.1	
Өөрийн орлого	17.3	7.4	5.9	-11.4	-65.9	-1.5	-20.3	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс **581.7** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 316.4 тэрбум төгрөг;
- Гаалийн албан татвар 129.3 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 122.1 тэрбум төгрөг;
- Хураамжийн орлого 18.3 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 12.1 тэрбум төгрөг;
- Автобензин, дизель түлшний албан татвар 2.3 тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар 1.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Харин Тамхины онцгой албан татвар 1.2 тэрбум төгрөг, өөрийн орлого 11.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

## Тав. Татварын чөлөөлөлт

2024 оны эхний 6 сард нийт импортод татвартай импорт 93.7 хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ 6.3 хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт

3,171.8 тэрбум төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт 270.6 тэрбум төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 9. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	эхний 6 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Татвартай импорт	13,875.1	17,047.0	3,171.8	22.9	93.7
Татвараас чөлөөлөгдсөн импорт	873.8	1,144.5	270.6	31.0	6.3
Нийт импорт	14,749.0	18,191.4	3,442.4	23.3	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын **1,144.5** тэрбум төгрөгийн бараанд 2024 оны эхний 6 сард ногдуулвал зохих **168.2** тэрбум төгрөгийн татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу татвараас чөлөөлөгдсөн байна.

### Хүснэгт 9. Татварын чөлөөлөлтийн бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Үнийн дүн, мян.төг	ДҮН
Бусад	235.2	33.1
Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	261.1	40.5
Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	172.4	27.0
Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	197.6	30.2
Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	106.3	17.0
Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	7.0	1.0
ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	121.0	12.7
Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	43.8	6.8
Нийт дүн:	1,144.5	168.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

## Зургаа. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлтэд нөлөөлсөн хүчин зүйлс

Гаалийн байгууллага улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийг зөв, оновчтой зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч цаг үеийн шаардлагатай УИХ, Засгийн газраас баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татварын хойшлуулалт, чөлөөлөлт, хөнгөлөлтөөр 224.6 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнд:

Тариф хувь хэмжээний бууралт 4.1 тэрбум төгрөг + татварын чөлөөлөлт 1.0 тэрбум төгрөг + ханшийн нөлөөллөөр 134.8 тэрбум төгрөг + Татварын хойшлуулалт 30.0 тэрбум төгрөг + БДШ акт 11.4 тэрбум төгрөг + тээвэр, ложистик хүндрэл 43.0 тэрбум төгрөг=Нийт **224.6** тэрбум төгрөг.



**Хүснэгт 10. Татварын чөлөөлөлт**

/тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	эхний 6 сар		Өөрчлөлт	
		2023	2024	Дүн	Хувь
1	Нийт импорт /сая ам. доллар/	4,250.4	5,386.4	1,136.0	26.7
2	Нийт импорт/тэрбум төгрөг/	14,749.0	18,191.4	3,442.5	23.3
3	Гаалийн албан татвар болон Нэмэгдсэн өртгийн албан татвар /тэрбум төгрөг/	2,171.8	2,617.4	445.6	20.5
4	Дундаж ханш /төгрөг/	3,470.0	3,377.3	-92.8	-2.7
5	2023 оны эхний 6 сарын дундаж ханшаар тооцсон импорт / тэрбум төгрөг/	14,749.0	18,691.0	3,942.0	26.7
6	2023 оны эхний 6 сарын дундаж ханшаар тооцсон татвар /тэрбум төг/	2,171.8	2,752.3	580.5	26.7
7	Ханшны зөрүүнээс буурсан татвар /тэрбум төг/		134.8		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Тарифын хөнгөлөлт, татварын чөлөөлөлт, хойшлуулалт**

1. Загийн газрын 2024 оны 188-р тогтоолоор батлагдсан Цементийн албан татварын хувь хэмжээг 20% байснийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд 5% болгон бууруулсан тогтоолыг тарифын санд оруулж хэрэгжилтэд хяналт тавьсан. Нийт 4.1 сая ам.долларын дүн бүхий 64 тонн, 4.1 тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн байна.

2. 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Засгийн газрын 180 дугаар тогтоолыг тус тус үндэслэн импортын малын тэжээл болон гурил бүхий бараанд ногдуулвал зохих 946.3 сая төгрөгийн гаалийн албан татварыг чөлөөлжээ.

3. Засгийн газрын 2022 оны 335 дугаар тогтоолыг хэрэгжүүлж Шивээхүрэн боомтын чингэлэг тээврийн терминалын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Эрчим хүчний сайд, “Шивээхүрэн терминал” ХХК, “Нарийн сухайт эрчим” ХХК-ийн хооронд 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр 25/Г-27/2033/012-23/А/2023-13/ тоот гэрээ байгуулагдаж, “Нарийн сухайт эрчим” ХХК гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжөөс 9.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий тоног төхөөрөмжийг 2023 оны 5 дугаар сарын 22-ноос эхлэн импортолж, 1.5 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

4. Засгийн газрын 2015 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Уул уурхайн сайд, “Монголын алт” ХХК, “Эрдэнэс цагаан суврага” ХХК-ийн хооронд 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдөр 41,20,195-2323/0012-5123 тоот гэрээг байгуулж, “Эрдэнэс цагаан суврага” ХХК-ийн гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийн үнийн дүнд 2023 оны 5 дугаар сарын 22-ноос эхлэн ногдуулсан 23.1 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

5. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Говь-Алтай аймгийн Тайшир суманд байрлах “Дөрвөлжин шохойн чулууны ордын цемент, шохойн үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтад зориулан импортоор оруулж ирсэн техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, “Цэнгазар” ХХК-ийн хооронд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 2024/73/47 тоот гэрээг байгуулж, 489.9 мянган ам доллар бүхий бараанд 2024 оны 3 дугаар сарын 31-нээс эхлэн 5.4 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна